

## **ОХУ-ын музейнүүдийн соёл боловсролын үйл ажиллагаа**

ОХУ-ын музейнүүд түр үзэсгэлэн, тайлбарт аялал -экскурс, сэдэвчилсэн хөтөлбөр, лекц, интерактив хичээл (сурагчдыг идэвхтэй оролцуулах), жүжиг, клуб, дугуйлан зэрэг соёл боловсролын олон төрлийн үйл ажиллагаа хүүхэд багачууд, насанд хүрэгчдэд зориулан байнга явуулж байна. Музейн “Музей- соён гэгээрүүлэх төв”, “Студи”, “Дадлагын газар” -ууд хөтөлбөрийн нэр, хэнд зориулсан, хүний тоо, цагийн хуваарь, үнэ төлбөр, захиалга өгөх хаяг, утас зэрэг мэдээллийг агуулсан товхимол, нугалбар, хуудас зэргийг хэвлэн түгээдэг. Энэ нь үзэгчдэд тасалбарыг урьдчилан худалдан авч, урт хугацаагаар хамрагдах боломж олгодог байна. Зарим нугалбараас орчуулан хүргэж байна.

### ***Санкт Петербург хот дахь Оросын угсаатны музей***

Музейн эрдэм шинжилгээ –арга зүйн хэлтэс “Нархан” нэртэй “Угсаатан-сурган хүмүүжүүлэх студи”-д 3 жилийн цуврал сургалт санал болгодог. “Сайн байна уу? Нархан минь” 3-4 насны, “Шидэт бөөрөнхий” 4-5 насны, “Үлгэрийн ном” 5-6 насны хүүхдийн сургалт юм. Нэг хичээл 45 минутаар сард 2 удаа Бямба гарагт 10 дугаар сараас 5 дугаар сар хүртэл явагдана. 3-4 настай хүүхдүүд эхний жил орос ардын үлгэр, оньсого таавар, дуу, хошин шүлэг сурч, зураг зурж, хатгамал, наамал хөрөг, зуурмагаар дүрс хийх зэргээр амьдралтай танилцдаг. 4-5 настай хүүхдүүд Орос орны байгаль орчин, байгаль хамгаалал, төрөл бүрийн сууцны тухай мэдэж, уламжлалт тоглоомоор тоглож, даалгавар биелүүлнэ. 5-6 настай хүүхдүүд үзмэрийн танхимаар аялаж, үлгэр сонсч, өөрийн үлгэрийн номоо бүтээдэг.

Музейн “Хүүхдийн студи” нэртэй өөр нэг студи 6-9 настай охид хөвгүүдэд зориулсан 3 жилийн сургалт явуулдаг байна. Эхний жилийн сургалт “Эрт цагийн Орос оронтой танилцах нь”, 2 дахь жилийн “Хүн ба байгаль”, 3 дахь жилийн “Оросын угсаатны газрын зураг” сургалтын үед хүүхдүүд Орос орноор музейд аялж, ёс заншил, аман өвтэй танилцан, зураач –багшийн удирдлага дор хичээллэнэ. [www.ethnomuseum.ru](http://www.ethnomuseum.ru)

### ***Санкт Петербург хот дахь Оросын улсын музей***

Музейн аялал-лекцийн хэлтэс “Хүүхдийн хөтөлбөр”-ийнхөө тухай нугалбар гаргажээ. Үүнд:

- “Бүтээлч хөгжлийн студи” 3-12 насны хүүхдийн зураг зурах, тоглох болон уян дасгал хөдөлгөөний хичээлийг үзмэрийн танхим дахь хичээлүүдтэй хослуулдаг. Мэргэшсэн, туршлагатай музейн ажилтнууд болон багш нар удирдан явуулдаг байна. Жил бүр студийн хичээлийн жилийн нээлт, хаалт, шинэ жил зэрэг баяруудыг Петербург хотын алдартай театрын оролцоотойгоор тэмдэглэдэг.

- “Залуу урлаг сонирхогчдын клуб” сэдэвчилсэн соёл- боловсролын цувралууд: музейгээс гадуурх лекц, байнгын үзмэрийн танхим болон түр үзэсгэлэнгийн тайлбарт аялал, мэргэжлийн зураач нар заадаг дадлага хичээл

- “Оросын музей Петербургийн сургуулиудад” сурагчдад зориулсан тайлбарт аялалын хөтөлбөр: бага ангийн сурагчид сонгосон хөтөлбөрийнхөө тасалбарыг худалдан авч, 1-4 жилийн хичээлээр дүрслэх урлагт суралцан, хаадын ордон, цэцэрлэгтэй танилцана. Дунд болон ахлах ангийн сурагчдын нийгмийн ухаан ба урлаг- гоо зүйн хичээлүүдийн хөтөлбөртэй уялдуулсан сэдэвчилсэн хичээлээр түүх, уран зохиол, дэлхийн урлаг, дүрслэх урлаг, Санкт Петербургийн түүх соёлтой танилцах хичээлийн тасалбар байна. Музейн шилдэг үзмэр урлагийн бүтээлүүдийг дэлхийн урлагийн түүхтэй холбон таниулснаар эх орныхоо түүх, дүрслэх урлагийг улам их танин мэдэх сонирхол төрүүлдэг байна.

- “Залуу хөтөч-орчуулагч нар” ахлах ангийн сурагчдыг Михайлов дахь Хааны ордны тойм тайлбар хийхэд сургах нэг жилийн 28 хичээл.

- “Музейн шидэт ертөнц” бага ангийн сурагчдад зориулсан музейнүүдийн хамтарсан хөтөлбөр. Хүүхдүүд жилийн турш Санкт Петербург хотын музейнүүдийг үзэж, зураг ба уран зургийн хичээлд хамрагдана. Энэ төсөл “Санкт Петербург ба Ленинград мужийн музейн сурган хүмүүжүүлэгч-боловсролын ажилтнууд ба тайлбарлагч нарын нийгэмлэг” бүс хоорондын олон нийтийн байгууллагын ивээл дор явагддаг.

- “Орос сургууль” нийгэм-соёл ба соён –гэгээрүүлэх төслөөр Санкт Петербург ба Ленинград мужийн хүүхдийн бүтээлийн үзэсгэлэнг танилцуулах баяр зохион байгуулдаг.

- “Маэстро! Сайн байна уу?” төслөөр хүүхэд, эцэг эхчүүд алдартай зураач уран бүтээлчидтэй сар бүр уулзаж, намтар уран бүтээлтэй нь танилцан хичээллэнэ. Мөн хаадын орд харш дахь лекц, концертуудад тэднийг урина. [www.rusmuseum.ru](http://www.rusmuseum.ru)

### ***Бүх Оросын чимэглэл – хэрэглээний урлаг ба ардын урлагийн музей***

“Музей-гэгээрлийн төв”-д үзэгчид гоёмсог танхимуудад эртний эдлэлийг гартаа барьж танилцах, “Эрт урьдын цагт амьдарч байжээ”, “Үл мэдэх зөргөөр”, Оросын матрёшка”, “Эмээгийн авдар” зэрэг сэдэвчилсэн, гэр бүлийн хөтөлбөр, тайлбарт аялал, дадлага ажил, урлагийн эмчилгээний тусгай хөтөлбөрүүдэд хамрагдах боломжтой.. Мөн “Музей бяцхан найзууддаа” , “Ардын урлаг: хаврын уулзалтууд”, “Ардын урлаг: Тоглоом ба шинжлэх ухаан” хөтөлбөрүүд байна. [www.vmdpni.ru](http://www.vmdpni.ru)

### ***Л.П.Кызласовын нэрэмжит Хакасын орон нутаг судлах үндэсний музей***

- “Музейтэй танилцах анхны уулзалт” 9 дүгээр сараас 12 дугаар сар хүртэлх түүх, археологи, байгаль шинжлэл, ёс заншил, баяр ёслолын хөтөлбөрүүдийн нэгдсэн тасалбар. [www.nhkm.ru](http://www.nhkm.ru)

### ***“Мартьяновын музейн гэрийн театр” студи***

- Оросын алдартай жүжгүүдийг үзэгчид тоглож, Бүх Оросын сайн дурын уран сайханчдын театрын урлагийн наадамд оролцдог байна.

***Минусинск хот дахь Декабристуудын музей (12 дугаар сарын хувьсгалчдын музей)***

- Нээлттэй хаалганы өдрийн хөтөлбөр дээр групп үзэгчдийн захиалгыг урьдчилан авах тухай зар байрлуулжээ.

**Бүгд Найрамдах Тува улсын Алтан Майдарын нэрэмжит Үндэсний Музейн соёл – боловсролын үйл ажиллагаа**

Бүгд Найрамдах Тува улсын Үндэсний музейн судалгаа хариуцсан орлогч захирал, Тувагийн улсын их сургуулийн музүй судлалын багш, доктор Анна Оюновна Дыртык –оолын тус музейн 85 жилийн ойн цомогт соёл-боловсролын үйл ажиллагааны тухай бичсэн болон түүний сургалт- арга зүйн гарын авлагаас сурагчдыг музейд тоглуулах тоглоомын хөтөлбөрийг тус тус товчлон орчуулав.

2008 онд шинэ барилгадаа орсон үндэсний музейн үзмэрт тулгуурласан олон нийтэд зориулсан арга хэмжээнүүд байнгын болон түр үзэсгэлэнг цогц болгож байдаг.

Тувагийн Үндэсний музей Тувагийн Бүгд найрамдах (БН) улсын нийслэл Кызыл хот болон бүгд найрамдах улсын түүхт ойн болон соёлын үйл ажиллагааны жагсаал, цуглаан зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээний нэг хэсгийг зохион байгуулдаг байна. Тухайлбал, “Хотын өдөр” иргэдийн зугаалга, баярын жагсаал, наадам соёлын амьдралын нэг хэсэг байна. 2011 онд хотын дарга байгууллага аж ахуйн нэгжүүдийн дунд түүхэн сэдвийг хэн хамгийн сайн харуулах вэ уралдаан зарлахад Үндэсний музей БНТува улсын түүхийг харуулсан тоглолт үзүүлж, 1 дүгээр байр эзэлж, 20 мянган рублийн шагнал авчээ. Мөн хотын Иргэдийн төлөөлөгчдийн хурал орчноо өвөрмөц тохижуулсан байгууллага шалгаруулахад шалгарч диплом, 30 мянган рублийн шагнал хүртсэн байна.

Музейн ажилтнууд үзэсгэлэн, конкурс, сэдэвчилсэн үдэшлэг, алдартай хүмүүстэй хийх уулзалт, дурсамж уулзалтыг тогтмол зохион байгуулдаг. 2008-2013 оны хамгийн их ач холбогдолтой арга хэмжээ:

- “Тувагийн хаадын хөндийн эрдэнэс. Хаадын булш Аржаан -2” үзэсгэлэнгийн нээлт 2008 онд Тува даяар баяр болсон.
- Музей байгуулагдсаны 80 жилийн ойн арга хэмжээнүүд, түүний дотор БН улсын хэмжээнд зохиогдсон “Музей чиний тухай дуулж байна” дууны уралдаан
- Кызыл хотын 95 жилийн ойд зориулсан, сургуулийн сурагчдын дунд зохион байгуулсан уран уншлагын уралдаан. 2009 он
- Музейн таксидермист И.М. Путинцевын 85 насны ойд зориулсан экологийн арга хэмжээ. 2010 он

- Музейн ахмад ажилтан, бөө судлаач эрдэмтэн, түүхийн ухааны доктор М.Б.Кенин- Лопсаны 85 насны ойд зориулсан, түүний амьдрал уран бүтээлийн тухай С.Шапиро-гийн “Шувууг гйүцэгч” киноны нээлт зэрэг арга хэмжээ
- Алдартай зураач Надя Рушева-гийн 60 насны ойд зориулсан бүс нутгийн конкурс. Уран зураг, уран зохиол, хөгжмийн бүтээлийн уралдаанд 170 хүүхэд хамрагдсан.
- Багш –орон нутаг судлаач нарын дунд зохион байгуулдаг уламжлалт уралдаан: 2009 онд газар зүйн багш нарын дунд, 2013 онд байгалийн ухааны багш нарын дунд, 2014 онд орос хэлний багш нарын дунд.

Музейн нэг жилийн календарчилсан арга хэмжээ:

Цагаан сар “Шагаа” музейн баяр Жилдээ 50 орчим удаа сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг хамардаг энэ баяр музейн брэнд болсон байна.

- Шинжлэх ухааны өдөр, Ялалтын баяр, Олон улсын музейн арга хэмжээ Шөнийн музей, Хүхэд хамгаалах өдөр, Орос улсын өдөр, “Мэдлэгийн өдөр” -т зориулсан “Сайн байна уу музей” боловсролын хөтөлбөр
- Байгаль экологийн баярууд
- Нээлттэй хаалаганы өдөр: музейн албадын өдөр тутмын ажилтай хүн амыг танилцуулдаг.
- Музейн шинэ барилгад нээгдсэн кино танхим уран сайхны болон баримтат кино үзүүлдэг.
- Сонгодог уран зохиол, Тувагийн ардын уламжлалт тоглоом, “Яагаад дугуйлан, “Угсаатны зүйн дугуйлан

Соёл боловсролын ажлын нэг хэсэг нь боловсролын хөтөлбөрүүд бөгөөд залуу үед эх оронч хүмүүжил, харилцан хүндлэл, эв эе, соёлын өвөө хүндлэх сэтгэлгээг суулгах зорилготой.

Тайлбарт аялал экскурс бол уламжлалт хэлбэр юм. Хамгийн талархал хүлээж буй аялал бол “Тувагийн хаадын хөндийн эрдэнэс. Хаадын булш Аржаан -2” юм.

ОХУ-ын Бүгд Найрамдах Тува улс 400 орчим мянга, Кызыл хот 110 гаруй мянган хүн амтай байхад Тувагийн үндэсний музейн үзэгчдийн тоо 2013 онд 40 763, тайлбарт аялал 1870, арга хэмжээ 168, лекц 63 байна.

## **“ОРОС ОРНООР АЯЛАХ АЯЛАЛ”**

**Бүгд Найрамдах Тува Улсын Үндэсний Музейн боловсруулсан,  
хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх тоглоом**

**Тоглоомын зорилго:** Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх, эрдэм мэдлэгийг нэмэгдүүлэх

**Зорилтууд:**

1. Өөрийн орны хүрээлэн буй орчин, түүхийг судлах сонирхол төрүүлэх
2. Хүүхдийн сэтгэлгээ болон анхаарлыг хөгжүүлэх
3. Ангийн хамгийн их эрдэм мэдлэгтэй хүүхдийг шалгаруулах
4. Эх оронч үзлээр хүмүүжүүлэх

**Хамрах хүүхдүүд:** Кызыл хотын Ерөнхий боловсролын дунд сургуулийн ахлах ангийн сурагчид

**Зохион байгуулах газар:** Боловсролын өрөө, хурлын танхим

**Тоног төхөөрөмж:** Слайд, проектор, “Хаадын эрдэнэсийн хөндий” үзэсгэлэнгийн тасалбар, өнгийн цаас, компьютер, “Орос орныг хэн сайн мэдэх вэ?” презентаци

**Тоглоомын явц:** “Орос орноор аялах аялал” долоон үе шатаас бүрдэнэ.

Хүүхэд нэг бүрд үе шат тус бүрийн өгөгдсөн хугацаанд хариулах асуултыг өгнө.

**Сурагчдын боловсролын түвшин:** Тоглоход гүнзгий мэдлэг шаардахгүй, гэхдээ дугуйлан, анги танхимын бус хичээл, уншиж олж авсан өргөн хүрээний мэдлэг хэрэгтэй.

**Музейн ажилтан хөтлөгчийн үг:**

Хайрт хүүхдүүдээ, эрхэм хүндэт зочдоо! Бид өнөөдөр “Орос орноор аялах аялал” хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх тоглоомыг тоглуулах гэж байна. Бид тоглохдоо эх орныхоо сонирхолтой олон түүхийг мэдэж, өөрөө өөртөө нээлт хийх ёстой. Хүүхдүүдээ манай сайхан орны хүн ам, араатан амьтан зэргийн тухай мэдлэгээ сорье.

Бидний **зорилго** бол та нарын хэн нь Орос орноо илүү сайн мэддэг, хэн хамгийн их мэдлэгтэй болохыг шалгаруулах юм.

### ***Тоглоомын дүрэм***

Тоглох 7-н сурагч гарч ирнэ үү. Тоглоом 7-н үе шатаас бүрдэнэ. Үе шат бүрд өөр өөр сэдвээр 7-н асуулт асууж, хариултыг 2 хувилбараар өгнө. Та нар зөв хариултыг сонгоно. Зөв хариулсан сурагч урагш 1 алхаж, 10-н оноо авна. Буруу хариулсан *сурагч байрандаа үлдэнэ*. Хамгийн олон оноо авсан сурагч музейн үзэсгэлэн үзэх тасалбараар шагнуулна. Манай оюун ухааны тоглоомд оролцогчдод амжилт хүсэн ерөөе.

За, тоглож эхэлье. **Анхаараарай. Асуулт! (Дэлгэц дээр асуулт гарна.)**

**“Орос орноор аялах аялал” тоглоом**

**Тоглоомын зорилго:**

1. Орос орныг хэн илүү сайн мэдэх вэ?
2. Энэ ангийн хамгийн их мэдлэгтэй сурагч хэн бэ?

Тоглоомын I үе шат

ОРОС ОРНЫ АМЬТАН БА УРГАМЛЫН ЕРТӨНЦ

1. Ямар шувууг орос ардын үлгэрт загас гэж нэрлэдэг вэ?  
А) Тахиа  
Б) Шаазгай
2. Өргөст хэмхийг Орос руу ямар орноос авчирсан бэ?  
А) Хятадаас  
Б) Энэтхэгээс
3. Наранцэцгийн үрийг хэн анх Орос оронд авчирсан бэ?  
А) Нэгдүгээр Петр хаан  
Б) Нэгдүгээр Александр хаан
4. Ямар махчин загас орос ардын үлгэрийн баатар вэ?  
А) Цурхай  
Б) Барракуда
5. Уламжлалт ёс заншлын дагуу шинэ байрандаа ямар амьтныг эхэлж оруулдаг вэ?  
А) Хулгана  
Б) Муур
6. Оросын хүрэн баавгай өвөл ичихээсээ өмнө юу хуримтлуулдаг вэ?  
А) Тэвчээр  
Б) Өөх
7. Ямар тасалгааны ургамлыг Орос оронд “Наполеоны чих” гэж нэрлэсэн бэ?  
А) Хайтан цэцэг  
Б) Зуун наст

Тоглоомын II үе шат

ХАМГИЙН, ХАМГИЙН, ХАМГИЙН .....

1. Оросын хамгийн цэвэр устай ямар тэнгис байдаг вэ?  
А) Япон тэнгис  
Б) Чукотскийн тэнгис
2. Оросын хамгийн өндөр оргилыг нэрлэнэ үү?  
А) Бешгтау  
Б) Эльбрус
3. Оросын хамгийн их устай голыг нэрлэнэ үү?  
А) Енисей  
Б) Лена
4. Орост байдаг дэлхийн хамгийн гүнзгий, хамгийн их талбай эзэлдэг нуурыг нэрлэнэ үү?  
А) Байкал  
Б) Хөвсгөл
5. Зөвхөн Оросын нутгаар урсдаг хамгийн урт голыг нэрлэнэ үү?  
А) Витим  
Б) Лена
6. Манай орны хамгийн жижиг шувууг нэрлэнэ үү?

- А) Хөхөө  
Б) Бор шувуу
7. Манай орны хамгийн том шувуу юу вэ?  
А) Хотон шувуу  
Б) Тэмээн хяруул

Тоглоомын III үе шат  
ОРОСТ ХАМГИЙН АНХ, ОРОСТ АНХ

Тоглоомын IV үе шат  
ОРОСЫН ХООЛ

Тоглоомын V үе шат  
ОРОС УЛС

Тоглоомын VI үе шат  
ОРОС ТАМИРЧИН ОРОН

Тоглоомын VII үе шат  
ЗӨВХӨН ОРОСЫН

**Хөтлөгч:**

Уншаад зөвхөн “тийм” эсвэл “үгүй” гэж хариулаарай.

Оролцсон та бүхэнд баярлалаа.

Ялагч энэ байна! Асуултуудад онц хариулж, мэдлэгээ харууллаа. Өөрийн орныг хамгийн сайн мэддэг гэдгээ баталж чадлаа.

Тиймээс ялагчийг “Хаадын эрдэнэсийн хөндий” үзэсгэлэнгийн тасалбараар шагнаж байна. Ялагчдаа бүгдээрээ халуун баяр хүргэж, гайхамшигтай үзэсгэлэн рүүгээ үдэж өгье. Тэнд ялагч маань эзэн хааны “Аржаан 2” булшны алтан олдворуудыг үзнэ. Бусад сурагчид идэвхтэй сайн оролцсон тул шагнал гардуулж байна.

Оролцогчид, зохион байгуулахад тусалсан хүмүүс, дэмжсэн үзэгчдэд маш их баярлалаа. Бид олон шинэ зүйл мэдэж авч, эрдэм мэдлэгээ шалгалаа. Дахин уулзатлаа баяртай.

Ном зүй: [www.ethnomuseum.ru](http://www.ethnomuseum.ru)

1. [www.rusmusrum.ru](http://www.rusmusrum.ru)
2. [www.vmdpni.ru](http://www.vmdpni.ru)
3. [www.vmdpni.ru](http://www.vmdpni.ru)
4. [www.nhkm.ru](http://www.nhkm.ru)
5. Дыртык –оол А.О.Культурно-образовательная деятельность музея. – Национальный музей имени Алдан –Маадыр Республики Тыва. 1929-2014. Юбилейный альбом посвящается 85- летию основания музея. Кызыл-2014. С.105.

6. Дыртык-Оол А.О. Музееведение: Культурно-образовательная деятельность музея. Учебно-методическое пособие. Кызыл.Тувинский государственный университет. 2015. Тал 65-68.

### Зургийн тайлбар

42. Сан хөмрөг Чимэглэл-хэрэглээний урлаг. Сан хөмрөгч Саида Лопсановна Бырыннай. Сан хөмрөгийн галын дохиоллын систем.

“Тувагийн хаадын хөндийн эрдэнэс. Хаадын булш Аржаан-2” үзмэрийн танхим:

1. Ерөнхий байдал
2. Бугын дүрслэлтэй бүхий үсний хатгуур
3. Хааны чинжал хутга

“Тувагийн хаадын хөндийн эрдэнэс. Хааны булш Аржаан- 2” Үзэсгэлэнгийн нээлтийн 5-н жилийн ойд зориулсан “Скифчүүдийн амьдралын нэг өдөр” уралдаан. 2013 оны 11 дүгээр сарын 1.

Тувагийн Үндэсний музейн анхны захирал, анхны мэргэжлийн гэрэл зурагчин В.П.Ермолаевын гэрэл зургийн ил захидлын цомог.

Гэрэл зураг: **Хүүхдээ хөхүүлэх гэж буй эмэгтэй.** (Тайлбарыг цомог хийсэн ажилтан бичсэнийг дурдсан)

Хүүхэд төрөхтэй холбогдолтой ёс заншил, уламжлалт өлгийний тухай тайлбар. Ил захидлын ард тайлбар, үзмэрийн хуучин, шинэ дугаар, шинэ дугаар өгсөн он, музейд авах бүртгэлийн дэвтэр, гэрэл зургийн нэр, материал, гэрэл зургийг авсан газар, он, сан хөмрөгийн нэр

Гэрэл зураг: **Бяцхан туслагч**

Хүүхдийг 5-6 наснаас нь хөдөлмөрч болгон хүмүүжүүлдэг байсан арга, тувачууд хүүхдийг зодож шийтгэдэггүй, ажил хийхээр магтаж урамшуулдаг уламжлалтай байсан тухай бичиж, “Хүүхэд энхрийлэхэд уриалагхан” гэсэн ардын үгийг бичжээ.

БНТува улсын Үндэсний музейн Түүх, орон нутаг судлах хэлтсийн “Угсаатан ястан олон – эх орон нэг” хөтөлбөр ба нэг хүний тасалбар 150 руб.

**Д.Бумаа Дэд проф, PhD**

(МҮМ-н Музей судлал мэргэжил арга зүйн төвийн дарга)